



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/351
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Биеийн тамир, спортын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэл өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар Биеийн тамир, спортын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг шинэчлээгүй, түрээсгүйгээр ашиглуулсан, 2 жилээс дээшхи авлагыг барагдуулаагүй, дараа тайлангийн авлагыг зардалд хаасан, Монголын жудо бөхийн холбоо 9,860.0 мянган төгрөгийн 58 ширхэг дэвжээг дутуу нийлүүлсэн, РИО-2016 зуны 31 дүгээр олимпын наадам, Тэмээн поло улсын аварга шалгаруулах 2016 оны тэмцээн, улсын шигшээ багийн гадаад дотоод уралдаан тэмцээнтэй холбоотой нийт 340,335.6 мянган төгрөгөөр төсвийн хөрөнгийг зориулт бусаар, үр ашиггүй зарцуулсан, төсвийн захирагчийн эрхийг зөрчиж, дээд шатны төсвийн захирагчид харъяалагдах ажилтануудад гадаад томилолтын 6,456.3 мянган

төгрөгийг олгосон, анхан шатны баримтын бүрдэлгүй 49,554.0 мянган төгрөгийг зардалд хаасан, төндөр зарлалгүйгээр нийт 243,008,7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, байгууллагын даргын хэрэгжээгүй 236,920,8 мянган төгрөгийн шийдвэрийг хүчингүй болгоогүй зэрэг нийт 734,224.2 мянган төгрөгийн алдаа зөрчлүүд илэрсэн нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Хязгаарлалттай дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Биеийн тамир, спортын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Ц. Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер:
Я. Самбууням
Утас: 260512

Шинжээч:
Б.Баярмаа
Утас: 260512

ТАБ-ын хаяг: ҮАГазар
Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 2 дугаар сар

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	4
5. Материаллаг байдлын түвшин	5
6. Дотоод хяналт	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
8. Шилэн дансны мэдээлэл	6
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	6
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	6
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:	7
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
17. Зөвлөмж	8
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	9

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг үндэслэн, Үндэсний Аудитын Газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий Аудитортай 2016 оны 9-р сарын 19-нд байгуулсан “Аудитын ажил гүйцэтгэх” 14/2017 дугаар гэрээний дагуу “Биеийн тамир, спортын газар”-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийлээ. Аудитын код: САГ-2017/288/СТА-ТШЗ

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Биеийн тамир, спортын газрын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан Төсөвт байгууллагын “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Биеийн тамир, спортын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 02-наас 2017 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-ийн багийн аудиторуд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Биеийн тамир, спортын газрын 2017 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 10-нд “Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК-нд ирүүлсэн.

“Монголиан Бизнес Рейтинг Аудит” ХХК аудитыг 2017 оны 02 дугаар сарын 02-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 26-нд Биеийн тамир, спортын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Биеийн тамир, спортын газрын дарга нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Биеийн тамир, спортын тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Тус байгууллагын зорилго: Биеийн тамир, спортыг өдөр тутмын хэрэглээ болгосноор хүн амыг эрүүл зөв амьдралд сургах, биеийн тамир, спортын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, үндэсний шигшээ багийн хариуцлага, дэг журмыг сайжруулах,

тамирчдын амжилтыг олимп, тив, дэлхийн наадмын түвшинд хүргэх, Монгол улсын нэр хүндийг олон улсын тавцанд мандуулахад оршино.

Биеийн тамир, спортын газар нь Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан дүрэмд заасны дагуу Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Олимп, тив, дэлхий, олон улсын томоохон тэмцээнд үндэсний шигшээ багийн тамирчдыг бэлтгэн оролцуулах, эх орондоо болох олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнийг зохион байгуулах, иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, чийрэгжилтийн арга хэмжээ, сургалт сурталчилгаа явуулах, биеийн тамир, спортын салбарын бодлого, хөтөлбөр, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргагчдыг нотолгоо, статистик тоо, мэдээллээр хангах, хүн амд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ хүргэдэг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон үндэсний шигшээ баг, спортын өндөр зэрэглэлийн тамирчдын бэлтгэл, дасгалжуулалтыг анагаах ухаан, судалгаа шинжилгээний үндсэн дээр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, салбарын хүний нөөцийн хөгжил, тэмцээн, наадмын тогтолцоо, биеийн тамир, спортын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах, чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус байгууллагын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын горим, хяналтын болон нарийвчилсан сорил, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, Шилэн дансны тухай хууль, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгон, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, гарын авлагын дагуу явуулав.

Аудитаар Биеийн тамир, спортын газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 32-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулахад тууштай мөрдөгдөх тухайн байгууллагын баталсан зүй тогтол болон тогтсон дэг журмын суурь юмаа. Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Биеийн тамир, спортын газрын нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Эмиралд санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх заавар журмын дагуу гаргаж бэлтгэсэн байна.

Материаллаг байдлын түвшин:

2016 оны санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, нийт орлогын батлагдсан төсөв болох 11,516,124.2 мянган төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1%-иар тооцож, материаллаг байдлын түвшинг 115.2 сая төгрөгөөр урьдчилан тогтоов.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтын дунд гэж үзэж байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Биеийн тамир, спортын газрын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамны төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлтыг авдаг байна. Төрийн сан нь төсвийн хүрээний мэдэгдлийн боловсруулалт, төсвийн санхүүжилт, төсвийн зардлыг хөтөлбөр, зориулалт, ангилалын дагуу хуваарилан, гүйцэтгэлд хяналт тавин ажилладаг байна.

2016 оны төсөв 2015 оноос 4,525,032.3 мянган төгрөг буюу 31,5 хувиар өссөн нь Рио-2016 зуны 31 дүгээр Олимпийн наадам тухайн онд зохион байгуулагдаж байгаатай холбоотой байна.

Биеийн тамир, спортын газарт 2016 онд 11,516,124.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр, 11,448,993.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 11,345,559.2 мянган төгрөгийн зарцуулалттай, зарцуулагдаагүй 103,433.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Аудитаар Үндэсний аудитын газраас нэгдсэн журмаар авч байгаа 3 судалгааг гаргуулан авсан. Судалгаагаар тайлант онд ажлаас 14 хүн халагдаж, 2 хүний гэрээ дуусаж чөлөөлсөн байна. Нийт 14 ажилтанд ажлаас халагдсаны 1 сарын тэтгэмж олгосон байна. Үндсэн хөрөнгийн судалгаагаар 392.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 8.3. “Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно” гэсэн заалтын дагуу тус байгууллагын вебсайт хуудсанд байршуулсан шилэн дансны мэдээллийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Төсөв гүйцэтгэлийн талаар

- Дараа жилийн төсвийн төслийг бүтэн жилээр байршуулсан
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар, улирал, хагас, бүтэн жилээр байршуулсан
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг сар бүр батлагдсан төсөв, гүйцэтгэлээр байршуулсан
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан хагас, бүтэн жилээр байршуулсан
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан бүтэн жилээр байршуулсан
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлэлд санхүүжилтийн орлогыг сар бүр байршуулсан
- Хагас жилийн санхүүгийн тайлан байршуулсан
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулсан
- Байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй

2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт

- Тамирчдад эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер, жилийн төлөвлөгөө байршуулсан
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр байршуулсан
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг сар бүр байршуулсан
- Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан төсөв, гэрээ, гүйцэтгэл, тайлбарыг бүтэн жилээр байршуулсан

3. Бусад мэдээлэл

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлийг сар бүр байршуулсан
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр байршуулсан
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байршуулсан
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг сар бүр байршуулсан
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр байршуулсан
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн сар бүр байршуулсан

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Эрүүл мэнд, спортын сайдын харьяа “Биеийн тамир спортын хөгжлийн төв”-ийг, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын харьяаны Засгийн Газрын

Хэрэгжүүлэгч Агентлаг “Биеийн тамир, спортын газар” болгон өөрчилж, 41 хүний орон тоотойгоор зохион байгуулагдсан байна.

Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тушаалаар Биеийн тамир, спортын газрын зохион байгууллалтын бүтэц орон тоог, 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаалаар “Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны чиг үүрэг, стратег”-ийг тус тус баталсан байна.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А-308/А-04/278 дугаар хамтарсан тушаалаар Засгийн газрын шинэчлсэн бүтэц, яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлагдсантай холбогдуулан өөрчлөн зохион байгуулах ажлын хэсгийн байгуулж, ажлыг хэсгийн удирдамжийг баталсан байна. Удирдамжийн дагуу Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн 2016 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хаалтын санхүүгийн тайланг гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн 2016 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хаалтын санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө 11,611.4 мянган төгрөг, авлага 255,672.8 мянган төгрөг, бараа материал 1,151,908.9 мянган төгрөг, биет хөрөнгө 1,366,925.5 мянган төгрөг, 715,505.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн 2016 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон хаалтын санхүүгийн тайлангийн талаар үүрэг хариуцлага хүлээх Д.Жаргалсайхан 2016 оны 7 дугаар сарын 28-ны өдрөөр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөж, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Ц.Шаравжамц Биеийн тамир, спортын газрын даргаар томилогдон ажиллаж байна.

Биеийн тамир, спортын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого санхүүжилт, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, цалин, НДШ, тогтмол зардал, авлага, өглөгийн дансдын ажил гүйлгээг түүвэрчлэн, нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, авлага, өр төлбөрийн 75 хувь, цалин, НДШ, тогтмол зардлын 70 хувь, үндсэн хөрөнгийн 50 хувийг тус тус эзэлж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 32 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 32 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Мөнгөн гүйлгээний тайланд жирэмсэн болон амаржсаны, ХЧТАТ-ын 5,909.9 мянган төгрөг, ХХОАТ-ын 494.0 мянган төгрөгийг орлогыг бүртгэж, тайлагнаагүй, Нэр дансны зөрүүгийн гүйлгээг, орлого зарцуулалтаар тайлагнасан, түрээслэгч байгууллагуудтай төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх гэрээг шинэчлэн байгуулаагүй, барьцааны гэрээгүй, түрээсгүйгээр ашиглуулсан, “Монголын жудо бөхийн холбоо” 9,860,000 төгрөгийн 58 ширхэг дэвжээг дутуу нийлүүлсэн, РИО-2016 Олимпийн наадам, тэмээн поло 2016 улсын аварга шалгаруулах тэмцээн, улсын шигшээ багийн тамирчдын дотоод, гадаад тэмцээн уралдаан тэмцээний дараа тайлангийн авлагын тооцоо бүрэн хийгээгүй, зардалд хаах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах хуулийн дагуу тендер шалгаруулалтгүй хөрөнгө бэлтгэсэн, томилолтын зардлыг давхардуулан олгосон, төсвийг зориулалт бусаар

зарцуулсан, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын хэрэгжээгүй тушаалыг хүчингүй болгоогүй, өглөг илүү бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитаар дараах алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

Нэг: Биеийн тамир, хөгжлийн төвийн 2016 оны 07 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хаалтын санхүүгийн тайланд хийсэн завсарын аудитаар:

1. Мөнгөн хөрөнгө, орлого санхүүжилтын талаар. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд жирэмсэн болон амаржсаны, ХЧТАТ-ын 5,909.9 мянган төгрөгийг орлогоор бүртгэж тайлагнаагүй
- Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод болсон Тэмээн поло улсын аварга шалгаруулах тэмцээний шагнал, шүүгчдийн урамшуулалд ногдуулсан ХХОАТ-ын 494.0 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, тайлагнаагүй. Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Гарсан алдааг аудитын явцад залруулсан

2. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны А/282 дугаар тушаалаар “Пара байт” харвааны шигшээ багийг Чех улсын Нова Место хотноо тэмцээнд оролцуулахаар 50,116.2 мянган төгрөгийн зардал батлагдаж, уг зардлаас “Пара байт” харвааны холбооны ерөнхийлөгч Баатаржавын хаан банкны 5130001872 тоот дансанд 14,158.8 мянган төгрөгийг шилжүүлж, дараа тайлан гаргагчийн тооцооны авлагаар бүртгэж тайлагнасан боловч гүйцэтгэлээр 13,548.1 мянган төгрөгийн зарцуулалт гарч, зөрүү 610.7 мянган төгрөгийг барагдуулаагүй дараа тайлангийн авлагыг хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн орлого болгох 610.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов

3. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны А/235 дугаар тушаалаар Жудо бөхийн үндэсний шигшээ багийг хэрэглэл материалаар хангах 500 ширхэг дэвжээг 85,000,000 төгрөгөөр бэлтгэх зардал батлагдаж, “Монголын жудо бөхийн холбоо”-нд 2016 оны 05-р сарын 10-ны өдрийн төлбөрийн хүсэлтээр 85,000,000 төгрөгийг шилжүүлсэн байна. Гэтэл тус холбоо 9,860,000 төгрөгийн 58 ширхэг дэвжээг дутуу нийлүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 9,860.0 мянган төгрөгийн 58 ш дэвжээг актаар хүлээн авч, данс бүртгэлд авч бүртгэж, тайлагнах албан шаардлага хүргүүлэв

4. РИО-2016 Олимпын наадмын зардлын зарцуулалтын талаар Үүнд:

- Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 05 сарын 31 өдөр А/285 тоот тушаалаар “Рио 2016” Зуны Олимп, Паралимпын наадмын ёслолын хувцаснаас олимпын наадмад оролцох бүрэлдэхүүнд албан ёсоор орох ёсгүй

албан тушаалтан, Спортын холбоод зэрэг 26 хүнд 32,760.0 мянган төгрөгний хувцас олгосон.

- Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 06 сарын 28 өдөр А/339 дугаар тушаалаар “Рио-2016” зуны олимпийн наадамд оролцохоор эрх авсан ҮШБагийн Боксын тамирчид Э.Цэндбаатар, Х.Энх-Амар нарыг ХБНГУ-ын Франкфуртээр дамжин нисэх тийзийн төлбөр 10,458.0 мянган төгрөгийг Айрмаркетэд шилжүүлсэн байна. Цэндбаатар ХБНГУ-ын улсын визгүй улмаас уг нислэгээр яваагүй учир 1,988.0 мянган төгрөгийн торгууль төлж, тийзийн төлбөр 5,229.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй шууд зардалд бичсэн. Гэтэл уг төлбөр Айрмаркетин хатуу нөхцөлтэй төлбөрийн шаардлагаар 5,229.0 мянган төгрөг буцаан олгогдохгүй болсон байна.
- “Рио-2016” зуны олимпийн наадамд бэлтгэл хангагчаар оролцогч, холбогдох албаны хүмүүст Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 06 сарын 27 өдөр А/329 дугаар тушаал “Рио-2016” зуны олимпийн наадмын 90 ширхэг 32,729.4 мянган төгрөгийн тасалбарыг “Жуулчин Уорлд Турс” ХХК-иар дамжуулан худалдан авч төсөвт батлагдаагүй, зориулалт бус зарцуулалт гаргасан.
- “Рио 2016” Зуны Олимпод оролцох тамирчид болон бусад холбогдох ажилтан, албан тушаалтан нарын байр, хоол, унааны зардлыг төсвийн хөрөнгөөр бүрэн хангасан байна. Гэтэл Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 07 сарын 04-ний өдөр А/347 тоот тушаалаар “Рио 2016” Зуны Олимпод оролцох штабын бүрэлдэхүүний 11 албан тушаалтан 31,629.7 мянган төгрөг, МУ-ын шадар сайд Ц.Оюунбаатар, МУ-ын БСШУСпортын сайд Д. Батсуурь нарт 7,454.2 мянган төгрөг, нийт 39,083.9 мянган төгрөгийн томилолтын мөнгийг давхардуулан олгосон байна.
- Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 07 сарын 25-ны өдөр А/386 тоот тушаалаар “Рио 2016” Зуны Олимпийн наадамд оролцох Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд Ж. Батсуурьт шаардагдах зардлыг гаргах 31,001.6 мянган төгрөгөөр батлагдаж, 28,366.4 мянган төгрөгийн бизнес ангиллын нислэгээр зорчиж, доод шатны захирагчийн төсвөөс гадаад томилолтын зардал гаргасан байна.
- Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 07 сарын 19-ны өдөр А/370 тоот тушаалаар Олимпийн багийн бүрэлдэхүүнд албан ёсоор оролцохгүй спортын холбоодын 6 хүний 20,922.6 мянган төгрөгийн тийзийн зардлыг баталж төсвийг зориулалт бус зарцуулсан байна.
- Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 07 сарын 04 өдөр А/351 дугаар тушаалаар батлагдсан Жудо бөхийн ҮШБагийн бүрэлдэхүүнийг “Монголын бөхийн олимп цогцолбор”-т бэлтгэл цугларалтын 94,735.0 мянган төгрөгийн зардлаас 16,944.3 мянган төгрөг, 2016 оны 07 сарын 19 өдөр А/368 тоот тушаалаар 14,300.0 мянган төгрөг, нийт 31,244.3 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг тамирчдын нэмэлт уураг, амин дэм, витаминжуулалтын зардал нэрээр супермаркетуудаас худалдан авсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол улсын засгийн газрын 2014 оны 5 сарын 10-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5-д “гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн

5. Тэмээн поло 2016 улсын аварга шалгаруулах тэмцээний зардлын талаар Үүнд:

Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн А/114 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод улсын аварга шалгаруулах Тэмээн поло тэмцээнийг 2016 оны 03-р сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулж, 27,648.7 мянган төгрөгийн зарцуулалт гарсан байна. Гэтэл Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А/325 дугаар тушаалаар Тэмээн поло улсын аварга шалгаруулах 2016 оны тэмцээнийг 150,000.0 мянган төгрөгөөр зохион байгуулах шийдвэрийг дахин гаргаж, тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2016 оны 06-р сарын 23-ны өдөр Эрүүл мэнд спортын яамны нөөц сангаас 150,000.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, Монголын тэмээн поло спорт уралдаан аялалын холбоонд 2016 оны 06 дугаар сарын 27-ны өдөр 5 удаагийн төлбөрийн хүсэлтээр уг мөнгийг шилжүүлсэн байна. Тэмцээн дахин зохион байгуулагдаагүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийн зарцуулалтыг гүнзгийрүүлэн шалгаж, тодруулах талаар Үндэсний аудитын газарт 2016.12.06-ны өдрийн 02/133 албан тоот хүргүүлсэн.

6. Анхан шатны баримтын бүрдэлийг хяналгүйгээр Улсын шигшээ багийн тамирчдын дотоод, гадаад тэмцээн уралдааны нийт 49,554.0 мянган төгрөгийн зардлыг шууд зардалд хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. /Хавсралт-1/

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн

7. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын тушаалаар нийт 243,008,7 мянган төгрөгийн тэмцээн уралдааны хувцас, хэрэглэлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах” хууль, журмын дагуу тендергүйгээр бэлтгэсэн. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах” гэсэн заалтыг зөрчсөн байна. /Хавсралт-2/

Шийдвэрлэсэн: “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн

8. Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргын 2016 оны 6 ширхэг тушаалаар нийт 236,920,8 мянган төгрөгийн тэмцээн уралдааны зардлын зарцуулалтын шийдвэрүүд батлагдсан боловч, уг шийдвэрүүд хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтыг зөрчсөн байна. /Хавсралт-3/

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн

